

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	3
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	4
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал.....	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	10
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	10
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	13
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	14
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	15
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН
ЦАХИЛГААН СТАНЦ ТӨСЛИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ж.ЛУВСАНДАНДАР ТАНАА

2020.03.09 № 06/756
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц” төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц” төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц” төслийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.1. Оршил

“Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц” төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг гүйцэтгэх захирал Ж.Лувсандандар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн авлага, өглөгийг барагдуулах, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц” төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц” төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 1 дүгээр сарын 22-наас 2020 оны 2 дугаар сарын 21-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Эс Жи Эм Ди -Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

“Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц” төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 8 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

“Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц” төслийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь: Баруун бүсийн эрчим хүчний системийн өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг найдвартай эх

үүсвэрээр хангах, импортын өндөр үнэтэй цахилгаан эрчим хүчийг дотоодын хямд эрчим хүчээр орлуулах, баруун бүсийн эрчим хүчний системийн горимын тохируулгын үүрэг гүйцэтгэх олон талын ач холбогдол бүхий 64 МВт-ын хүчин чадалтай усан цахилгаан станцыг барьж байгуулан ашиглалтад оруулахад энэхүү төслийн гол зорилго оршиж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд хуулийн үйлчлэх хүрээ, хуулийн нэр томъёо, тендерт оролцогчдод давуу эрх олгох, тендер ирүүлэх болон хүчинтэй хугацаа
- Нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хуульд ажил олгогчоос болон ажилтнаас төлөх нийгмийн даатгалын хувь хэмжээ
- ХХОАТ-ын тухай хуульд татварын хөнгөлөлтийн хувь хэмжээ

“ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨСЛИЙН 2019 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ОНЦЛОХ АЖЛУУД

Баруун бүсэд Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын төслийг хэрэгжүүлж, усан цахилгаан станцыг барьж байгуулан ашиглалтад оруулснаар агаарын бохирдлыг арилгах болон эрчим хүчний хангамжийн аюулгүй байдлыг урт хугацаанд баталгаажуулах гэсэн улс орны өмнө тулгамдсан 2 том асуудлыг шийдвэрлэнэ гэж үздэг байна.

Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц баригдах болон нуур үүсэх нутаг дэвсгэр 28,000 га газрыг Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдааны №357 дугаар тогтоолоор улсын тусгай хэрэгцээнд авч, хилийн заагийн эргэлтийн цэгийн солбилцол, талбайн хэмжээг батлан шийдвэрлэжээ. Үүний дагуу Ховд, Увс, Баян-Өлгий аймгийн Засаг дарга нар болон Ховд аймгийн Мянгад Эрдэнэбүрэн сум, Увс аймгийн Өмнөговь сум, Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын Засаг дарга нартай “УЛСЫН ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭНИЙ ГАЗРЫГ АШИГЛАХ ГЭРЭЭ”-г байгуулсан байна.

Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газраас 2019 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн улсын тусгай хэрэгцээний газрын гэрчилгээ, улсын тусгай хэрэгцээний газрыг ашиглах гэрээ, кадастрын зураг-ийг хүлээн авч Эрчим хүчний яаманд хүлээлгэн өгсөн байна.

2019 онд “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц” төслийн хүрэх түвшин, түүний биелэлт:

1.БНХАУ-аас тавьсан шаардлагын дагуу хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэн, ТЭЗҮ-ийг шинэчлэн боловсруулах

-Төсөл хэрэгжүүлэх нэгжийн зүгээс БНХАУ-ын Төрийн өмчит China Water Resources Beifang Investigation Design and Research /BIDR/ компаниар Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын шинэчилсэн ТЭЗҮ-г гүйцэтгүүлэхэд эргэн төлөгдөх нөхцөлгүйгээр санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэж чадсан байна. Үүний дагуу БНХАУ-ын Төрийн өмчит China Water Resources Beifang Investigation Design and Research /BIDR/ компани суурь судалгааны ажил эхэлж 2019 оны 10 дугаар сарын 31-ний өдөр “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц” төслийн ТЭЗҮ-ний тайланг эцэслэн боловсруулж гүйцэтгэн ЭХЯ-нд хүлээлгэн өгсөн байна.

2. Шинэчлэн боловсруулах ТЭЗҮ-г хятадын талд хүлээлгэн өгөх нөхцөл бололцоог бүрдүүлж, бэлтгэл ажлыг ханган ажиллах.

-Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц баригдах болон нуур үүсэх нутаг дэвсгэр 28,000 га газрыг Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдааны №357 дугаар тогтоолоор улсын тусгай хэрэгцээнд авч, хилийн заагийн эргэлтийн цэгийн солбилцол, талбайн хэмжээг батлан шийдвэрлэсэн байна. “Байгаль

орчинд нөлөөлөх байдлын тухай” хуулийн хүрээнд “Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ”-ний тайланг эрх бүхий мэргэжлийн байгууллага болох “Нью Гидро Проект” ХХК-иар хийж гүйцэтгүүлж БОАЖЯ-аар батлуулсан байна. Үүний үр дүнд тулгуурлан БОАЖЯ-ны Ерөнхий шинжээчийн “Байгаль орчны Ерөнхий үнэлгээний дүгнэлт” гарчээ.

- Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төслийн шинэчилсэн ТЭЗҮ-г Эрчим хүчний яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, шинэчлэн боловсруулсан ТЭЗҮ болон Байгаль орчны ерөнхий үнэлгээг Сангийн сайдын 2019 оны 10-1/7709 тоотойр БНХАУ-ын Элчин сайдын яаманд хүргүүлсэн байна.

Мөн төсөл хэрэгжүүлэх явцад яаралтай шийдвэрлэх шаардлагатай дараахь анхаарал татаж байгаа асуудал байна. Үүнд:

1. Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын Техник эдийн эдийн засгийн үндэслэлийг 2019 онд боловсруулж гүйцэтгэхэд төсөл хэрэгжүүлэх нэгж нь авто машингүй байсан байна. Улаанбаатар-Ховд аймаг-төслийн талбар гэсэн маршрутаар ажиллаад ирэхэд 2 талдаа ойролцоогоор 3,500-4,000 км зам туулдаг байна. Цаашид төслийн хөрөнгийг хэмнэх, ажил шуурхай зохион байгуулах, хил гааль дээрхи асуудлыг шийдвэрлэх, төслийн инженер техникийн ажилтнуудын аюулгүй байдлыг хангах зэрэг шаардлагын улмаас туулах чадвар сайтай автомашинтай болох зайлшгүй шаардлага байна.

2. Мөн төслийн талбарт ажиллах инженер техникийн ажилтнуудын ажиллах, амьдрах нөхцөлийг хангаж, хөрөнгө санхүүгийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна. (Төслийн талбарт оффис болон амьдрах түр байр)

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц” төслийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous 3.0” программ хангамж ашигладаг байна.

“Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц” төслийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц” төслийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 9 эрсдэлтэй асуудалд 9 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд 2019 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 392,966.7 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 3,929.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

“Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц” төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,320,1 мянган төгрөгөөр буюу 18.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	мянган төгрөгөөр		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	0	16.6	16.6
Бараа материал	0	218.2	218.2
Үндсэн хөрөнгө	7,147.9	5,593.0	(1,554.9)
Нийт хөрөнгө	7,147.9	5,827.8	(1,320.1)
Өр төлбөр	0	328.5	328.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	7,147.9	5,499.3	(1,648.6)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	7,147.9	5,827.8	(1,320.1)

Авлага дансны үлдэгдэл 16.6 мянган төгрөгөөр өссөн нь ажиллагсдын ХХОАТ-н хөнгөлөлтийг Татварын хэлтсээс авах авлага үүссэн. Авлага дансны үлдэгдэлд 2019 оны 12 сард үүссэн 16.6 мянган төгрөгийн байгууллагаас авах авлага байна. Энэхүү авлагыг 2020 оны 1 сард ажиллагсдын цалин олгоход тооцно.

Бараа материалын дансны үлдэгдэл 218.2 мянган төгрөгөөр өссөн нь шатахууны картын данс дахь урамшууллын 218.2 мянган төгрөгийг шатахуун зарцуулах эрхийн ашиглаагүйгээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,554.9 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлийн дүн өссөнтэй холбоотой. Тайлант хугацаанд үндсэн хөрөнгө бэлтгээгүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 328.5 мянган төгрөгөөр өссөн нь хувь хүмүүст өгөх өглөг 16.6 мянган төгрөг, байгууллагад өгөх өглөг 311.8 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 5,499.3 мянган төгрөг болж 1,648.6 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардал 1,554.9 мянган төгрөгөөр, бусад зардал 93.7 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх Эрдэнэбүрэнгийн УЦС төсөл хөтөлбөрт зориулан 391,100.0 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 369,092.0 мянган төгрөг буюу 94 хувьтай байгаа нь 2019 онд төслийн нэгж зарим үед бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллаагүйгээс цалин болон нийгмийн даатгалын зардал, томилолтын зардал хэмнэгдсэнээс шалтгаалсан байна. Зарцуулаагүй үлдэгдэл 22,007.7 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 9 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 4 эрсдэл тодорхойлж нийт 13 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 345.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 345.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар тендерийн ажлыг зохион байгуулсан талаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

“Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц” төслийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан шилэн дансны 16 үзүүлэлтийн дагуу мэдээлэл байршуулдаг бөгөөд 2019 онд хуулийн хугацаанд 100, хугацаа хоцроож 5 мэдээлэл байршуулан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар үе шатны хэсэгчилсэн аудитад хамрагдсан ба аудитаар албан шаардлага, акт, зөвлөмж өгөгдөөгүй байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц” төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Залруулагдаагүй 345.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийн дүн бидний тооцсон 3,929.7 мянган төгрөгийн материаллаг байдлын дүнгээс бага тул зөрчилгүй дүгнэлт өгч байна.

“Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц” төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

2. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, авлага, өглөг, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 16.6 мянган төгрөгийн байгууллагаас авах авлагатай байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;” Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2. Эрсдэл:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтыг мөрдөхгүй байх,

1.3. Өгсөн зөвлөмж:

Оны эцэст ХХОАТ-ын хөнгөлөлтийн тохируулгыг зөв хийж, авлага үүсгэхгүй ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлийг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

2. Балансын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 22,007.7 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн атал харилцагч байгууллагад 328.5 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8. “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “... эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

2.2. Эрсдэл:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтыг мөрдөхгүй байх,

2.3. Өгсөн зөвлөмж:

Төлбөр тооцоог хянаж, өглөг үүсгэхгүй ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлийг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн. Цаашид богино хугацаат өр төлбөр үүсгэхгүй ажиллахад анхаарна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	-	234,833.06
33	АВЛАГА	-	16,662.50
335	Бусад авлага	-	16,662.50
3351	Байгууллагаас авах авлага	-	16,662.50
35	БАРАА МАТЕРИАЛ	-	218,170.56
354	Хангамжийн материал	-	218,170.56
35440	Түлш, шатах тослох материал	-	218,170.56
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,147,899.91	5,592,993.26
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,147,899.91	5,592,993.26
392	Биет хөрөнгө	7,147,899.91	5,592,993.26
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	17,885,780.00	17,885,780.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(17,331,083.43)	(17,885,780.00)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,002,100.00	10,002,100.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(3,408,896.66)	(4,409,106.74)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	7,147,899.91	5,827,826.32
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	328,480.66
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	328,480.66
413	Өглөг	-	328,480.66
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	-
4136	Бусад өглөг	-	328,480.66
41361	Байгууллагад төлөх өглөг	-	311,818.16
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	16,662.50
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,147,899.91	5,499,345.66
51	Засгийн газрын хувь оролцоо	7,147,899.91	5,499,345.66
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	27,887,880.00	27,887,880.00
51101	Өмч: - төрийн	27,887,880.00	27,887,880.00
512	Хуримтлагдсан үр дүн	(20,739,980.09)	(22,388,534.34)
51220	Тайлант үеийн үр дүн	(20,739,980.09)	(22,388,534.34)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	7,147,899.91	5,827,826.32

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	206,517,957.35	391,318,170.56
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	218,170.56
120	Нийтлэг татварын бус орлого	-	218,170.56
120009	Бусад орлого	-	218,170.56
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	206,517,957.35	391,100,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	206,517,957.35	391,100,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	206,517,957.35	391,100,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	212,235,141.35	392,966,724.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	212,235,141.35	392,966,724.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	212,235,141.35	370,958,972.49
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,620,406.23	31,978,368.31
210201	Тэтгэврийн даатгал	16,620,406.23	21,745,290.43
210202	Тэтгэмжийн даатгал	-	2,558,269.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	2,046,615.58
210204	Ажилгүйдлийн даатгал	-	511,653.89
210205	Эрүүл мэндийн даатгал	-	5,116,538.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,140,000.00	37,140,000.00
210304	Байрны түрээс	37,140,000.00	37,140,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,066,800.50	8,581,929.00
210401	Бичиг хэрэг	3,996,260.00	3,348,178.16
210402	Тээвэр, шатахуун	2,686,144.50	2,849,406.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	2,384,396.00	2,384,344.84
2105	Нормативт зардал	-	2,094,352.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	2,094,352.00
2107	Томилолт, зочны зардал	17,107,275.00	24,085,969.00
210702	Дотоод албан томилолт	17,107,275.00	24,085,969.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	124,490,038.62	255,826,947.53
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	124,490,038.62	255,826,947.53
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,810,621.00	11,251,406.65
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,093,437.00	9,696,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	5,717,184.00	1,554,906.65
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	22,007,752.32
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	22,007,752.32
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	22,007,752.32
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(5,717,184.00)	(1,648,554.25)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(5,717,184.00)	(1,648,554.25)

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	206,517,957.35	391,100,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	206,517,957.35	391,100,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	206,517,957.35	391,100,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	206,517,957.35	391,100,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	206,517,957.35	391,100,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	206,517,957.35	391,100,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	206,517,957.35	369,092,247.68
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,620,406.23	31,978,367.99
210201	Тэтгэврийн даатгал	16,620,406.23	21,745,290.48
210202	Тэтгэмжийн даатгал	-	2,558,269.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	2,046,615.20
210204	Ажилгүйдлийн даатгал	-	511,653.90
210205	Эрүүл мэндийн даатгал	-	5,116,538.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,140,000.00	37,140,000.00
210304	Байрны түрээс	37,140,000.00	37,140,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,066,800.50	8,270,110.84
210401	Бичиг хэрэг	3,996,260.00	3,036,360.00
210402	Тээвэр, шатахуун	2,686,144.50	2,849,406.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	2,384,396.00	2,384,344.84
2105	Нормативт зардал	-	2,094,352.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	2,094,352.00
2107	Томилолт, зочны зардал	17,107,275.00	24,085,969.00
210702	Дотоод албан томилолт	17,107,275.00	24,085,969.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	124,490,038.62	255,826,947.85
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	124,490,038.62	255,826,947.85
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,093,437.00	9,696,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,093,437.00	9,696,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	22,007,752.32
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	22,007,752.32
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	22,007,752.32

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	27,887,880.00		(15,022,796.09)	12,865,083.91
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	27,887,880.00	-	(15,022,796.09)	12,865,083.91
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-		-	-
Тайлант үеийн үр дүн		-	(5,717,184.00)	(5,717,184.00)
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	27,887,880.00	-	(20,739,980.09)	7,147,899.91
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	27,887,880.00	-	(20,739,980.09)	7,147,899.91
Тайлант үеийн үр дүн	-	-	(1,648,554.25)	(1,648,554.25)
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	27,887,880.00	-	(22,388,534.34)	5,499,345.66

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	391,100,000.00	369,092,247.68	22,007,752.32	94.3
УРСГАЛ ЗАРДАЛ	391,100,000.00	369,092,247.68	22,007,752.32	94.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	391,100,000.00	369,092,247.68	22,007,752.32	94.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,300,000.00	31,978,367.99	1,321,632.01	96
Тэтгэврийн даатгал	22,644,000.00	21,745,290.48	898,709.52	96
Тэтгэмжийн даатгал	2,664,000.00	2,558,269.47	105,730.53	96
ҮОМШӨ-ний даатгал	2,131,200.00	2,046,615.20	84,584.80	96
Ажилгүйдлийн даатгал	532,800.00	511,653.90	21,146.10	96
Эрүүл мэндийн даатгал	5,328,000.00	5,116,538.94	211,461.06	96
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,140,000.00	37,140,000.00	-	100
Байрны түрээс	37,140,000.00	37,140,000.00	-	100
Хангамж, бараа материалын зардал	9,136,800.00	8,270,110.84	866,689.16	91
Бичиг хэрэг	3,501,400.00	3,036,360.00	465,040.00	87
Тээвэр, шатахуун	2,995,400.00	2,849,406.00	145,994.00	95
Шуудан, холбоо, интернетийн төлбөр	2,640,000.00	2,384,344.84	255,655.16	90
Нормативт зардал	2,100,000.00	2,094,352.00	5,648.00	99.7
Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,100,000.00	2,094,352.00	5,648.00	99.7
Томилолт, зочны зардал	33,311,000.00	24,085,969.00	9,225,031.00	72.3
Дотоод албан томилолт	33,311,000.00	24,085,969.00	9,225,031.00	72.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	266,400,000.00	255,826,947.85	10,573,052.15	96
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	266,400,000.00	255,826,947.85	10,573,052.15	96
Бараа үйлчилгээний бусад зардал	9,712,200.00	9,696,500.00	15,700.00	99.8
Бараа үйлчилгээний бусад зардал	9,712,200.00	9,696,500.00	15,700.00	99.8
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	391,100,000.00	369,092,247.68	22,007,752.32	94.3
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	391,100,000.00	369,092,247.68	22,007,752.32	94.3
Улсын төсвөөс санхүүжих	391,100,000.00	369,092,247.68	22,007,752.32	94.3
АЖИЛЛАГСДЫН ТОО	6	6	-	100
Удирдах ажилтан	1	1	-	100
Гүйцэтгэх ажилтан	5	5	-	100

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020.02.23	Аудитын нэр: ЭБУЦС төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2020/12/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц” төсөл ТХН	Мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 16.6 мянган төгрөгийн байгууллагаас авах авлагатай байна.	16.6	Зөвлөмж	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч	Ж.Лувсандандар Б.Отгон
2	Оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 22,007.7 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн атал харилцагч байгууллагад 328.5 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.	328.5	Зөвлөмж	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч	Ж.Лувсандандар Б.Отгон
	Нийт дүн	345.1			

